



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Булган дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/25/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: С.Оюунжаргал

Утас: 99911390

Цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	4
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
<b>3.5.1 Төсвийн төлөвлөлт</b> .....	12
<b>3.5.2 Төсвийн гүйцэтгэл</b> .....	12
<b>3.5.3 Нэмэлт төсөв</b> .....	13
<b>3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ...</b> Error! Bookmark not defined.	
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	13
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	13
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	13
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	14
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	14
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	14
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	14
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	15
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b> .....	16
<b>Аудитын гол асуудал</b> .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МХГ	Мэргэжлийн хяналтын газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН БУЛГАН  
ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГА О.ЛХАГВА-ЭРДЭНЭ ТАНАА

2023.02.08 № 02/18  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Булган дахь Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Булган дахь гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой Ховд аймгийн Булган дахь гаалийн газарт 4 төрлийн 101 ширхэг 517.8 сая төгрөгийн балансын үнэтэй 422.8 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 95.07 сая төгрөгийн үлдэх өртөгтэй Булган боомтын мэргэжлийн хяналтын газрын экспорт импорт хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн балансаас балансад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 03 сарын 17-ны өдрийн 90 дугаар тогтоолоор шилжүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

021020182

## **Бусад асуудлын хэсэг**

Гаалийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх зорилтуудын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө 46 ажил үйлчилгээ тусган бөгөөд байгууллагын стратеги зорилтыг хангахад чиглэсэн нийт 33, төсвийн шууд захирагчийн тусгайлан сонгосон тусгай 6, дотоод ажил үйлчилгээнд тусгагдсан 7 ажил үйлчилгээний биелэлтүүдийг тус тус ханган ажиллажээ.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



*Х. Болдбаатар*  
ХБОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>91,863,594.22</u></b>	<b><u>110,688,393.41</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	6,350,349.10
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	6,350,349.10
3351	Байгууллагаас авах авлага	-	6,350,349.10
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	91,863,594.22	104,338,044.31
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	76,737,094.39	90,188,044.48
35410	Бичиг хэргийн материал	3,535,786.00	2,299,776.00
35420	Аж ахуйн материал	3,985,362.00	10,306,062.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,990,000.00	1,650,000.00
35440	Түлш, шатах төслох материал	13,725,679.91	15,006,500.00
35470	Бусад хангамжийн материал	53,500,266.48	60,925,706.48
35600	Мал амьтад	15,126,499.83	14,149,999.83
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,603,660,163.10</u></b>	<b><u>2,664,867,894.51</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,603,660,163.10	2,664,867,894.51
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,471,542,527.10	2,533,357,758.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,672,680,019.80	2,724,377,904.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(548,287,324.36)	(623,022,961.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	249,892,000.00	249,892,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(221,192,000.00)	(233,492,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	793,072,653.62	1,376,665,682.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(477,289,488.68)	(996,572,923.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,872,040.00	66,770,875.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,205,373.28)	(31,260,817.95)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	132,117,636.00	131,510,136.00
39301	Програм хангамж	3,665,872.11	14,754,105.11
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,685,872.11)	(13,381,605.11)
39303	Бусад биет бус хөрөнгө	130,137,636.00	130,137,636.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,695,523,757.32</u></b>	<b><u>2,775,556,287.92</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>388,500.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	388,500.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	388,500.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	388,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	388,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,695,523,757.32</u></b>	<b><u>2,775,167,787.92</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,695,523,757.32	2,775,167,787.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,709,192,809.65	2,709,192,809.65
51101	Өмч: - төрийн	2,709,192,809.65	2,709,192,809.65
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(79,172,886.37)	471,144.23
51210	Өмнөх үеийн үр дүн	67,422,424.98	(79,172,886.37)

51220	Тайлант үеийн үр дүн	(146,595,311.35)	79,644,030.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	65,503,834.04	65,503,834.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,695,523,757.32</b>	<b>2,775,556,287.92</b>

## 2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүдэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>861,795,850.0</b>	<b>1,524,709,857.11</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>29,144,650.0</b>	<b>279,716,057.11</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	29,144,650.0	279,716,057.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,444,500.0	279,716,057.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,444,500.0	6,048,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		273,667,157.11
120005	Түрээсийн орлого	1,392,300.0	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>832,651,200.0</b>	<b>1,244,993,800.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	832,651,200.0	1,244,993,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	832,651,200.0	1,244,993,800.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>998,419,776.4</b>	<b>1,444,894,826.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>998,419,776.4</b>	<b>1,444,894,826.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	973,456,871.2	1,360,518,313.9
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	546,974,107.9	872,089,828.9
210101	Үндсэн цалин	519,688,107.9	782,302,374.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,286,000.0	69,732,000.0
210104	Урамшуулал	-	20,055,454.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	71,531,522.9	106,215,035.2
210201	Тэтгэврийн даатгал	50,750,802.0	72,709,029.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,981,307.0	8,543,133.3
210203	ҮОМЦӨ-ний даатгал	6,590,715.0	6,760,586.1
210204	Ажилгүйдлийн даатгал	900,035.3	1,654,753.7
210205	Эрүүл мэндийн даатгал	9,308,663.6	16,547,533.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	93,747,307.0	115,968,178.8
210301	Гэрэл, цахилгаан	44,500,000.0	72,650,528.8
210302	Түлш, халаалт	47,349,357.0	42,931,000.0
210303	Цэвэр, бохир ус	1,897,950.0	386,650.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,142,520.1	18,834,559.3
210401	Бичиг хэрэг	2,063,270.0	3,742,650.0
210402	Тээвэр, шатахуун	12,808,355.1	11,783,332.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,799,145.0	816,176.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, акуйн эд зүйлс	3,252,350.0	2,492,400.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	8,266,950.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	8,266,950.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,454,440.0	21,372,220.0

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,208,400.0	540,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,028,780.0	14,506,950.0
210604	Урсгал засвар	24,217,260.0	6,325,270.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,663,000.0</b>	<b>1,682,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	1,663,000.0	1,682,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,765,218.5</b>	<b>17,679,916.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,017,000.0	5,040,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,415,150.0	2,499,300.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,625.0	240,800.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.0	99,601.0
210807	Газрын төлбөр	130,242.0	2,228,195.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,314,201.5	7,572,020.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>190,178,754.8</b>	<b>200,962,125.7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,552,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	330,000.0	90,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	189,848,754.8	198,319,625.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,962,905.2</b>	<b>81,824,012.6</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>1,700,000.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,700,000.0
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>24,962,905.2</b>	<b>80,124,012.6</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,962,905.2	80,124,012.6
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(136,623,926.4)</u></b>	<b><u>79,815,030.0</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,971,385.0</b>	<b>171,000.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	9,911,585.0	171,000.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(146,595,311.4)</u></b>	<b><u>79,644,030.6</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Гөгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>841,271,700</u></b>	<b><u>1,252,661,200</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,620,500</b>	<b>7,667,400</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>8,620,500</b>	<b>7,667,400</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,300,000	6,000,000

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,300,000	6,000,000
120005	Түрээсийн орлого	2,320,500	1,667,400
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>832,651,200</b>	<b>1,244,993,800</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	832,651,200	1,244,993,800
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	832,651,200	1,244,993,800
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>841,271,700</b>	<b>1,252,661,200</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>841,271,700</b>	<b>1,252,661,200</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>815,380,595</b>	<b>1,170,837,187</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	546,974,108	874,655,960
210101	Үндсэн цалин	310,271,997	464,440,077
210102	Нэмэгдэл	167,616,111	268,227,321
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,286,000	69,658,292
210104	Урамшуулал	41,800,000	72,330,270
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	71,531,523	109,999,253
210201	Тэтгэврийн даатгал	50,750,802	75,575,832
210202	Тэтгэмжийн даатгал	3,658,985	8,810,120
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,469,636	6,940,576
210204	Ажилгүйдлийн даатгал	876,600	1,697,520
210205	Эрүүл мэндийн даатгал	8,775,500	16,975,204
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	98,157,807	118,590,679
210301	Гэрэл, цахилгаан	44,500,000	72,325,029
210302	Түлш, халаалт	51,759,857	44,470,000
210303	Цэвэр, бохир ус	1,897,950	1,795,650
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,271,430	16,117,729
210401	Бичиг хэрэг	2,669,400	2,561,600
210402	Тээвэр, шатахуун	12,998,035	11,525,153
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,799,145	859,477
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	219400.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,585,450	1,171,500
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	19,547,200
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	19,076,200
210502	Хоол, хүнс	-	471,000
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	62,156,210	20,046,470
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,159,800	1,141,500
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,997,200	8,911,000
210604	Урсгал засвар	44,999,210	9,993,970
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	1,663,000	1,682,000
210702	Дотоод албан томилолт	1,663,000	1,682,000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,316,517	10,107,896

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,017,000	5,040,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	582000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,415,150	2,499,300
210804	Тээврийн хэрэгслийн тагвар	206,625	240,800
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000	99,601
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	179100.00	0.00
210807	Газрын төлбөр	130,242	2,228,195
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1686400.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,310,000</b>	<b>90,000</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1980000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	330,000	90,000
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,891,105</b>	<b>81,824,013</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>1,700,000</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,700,000
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>928200.00</b>	<b>0.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	928200.00	0.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>24,962,905</b>	<b>80,124,012.64</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,962,905	80,124,012.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,633,192,809.65	67,527,034.04	65,399,224.98	2,766,119,068.67
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	76,000,000.00	0.00	2,023,200.00	78,023,200.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,709,192,809.65	67,527,034.04	67,422,424.98	2,844,142,268.67

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-2,023,200.00	0.00	-2,023,200.00
C07	Тайлант үеийн үр дүн			-146,595,311.35	-146,595,311.35
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,709,192,809.65	65,503,834.04	-79,172,886.37	2,695,523,757.32
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,709,192,809.65	63,480,634.04	-225,768,197.72	2,695,523,757.32
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,709,192,809.65	65,503,834.04	-79,172,886.37	2,695,523,757.32
D08	Тайлант үеийн үр дүн			79,644,030.60	79,644,030.60
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,709,192,809.65	65,503,834.04	471,144.23	2,775,167,787.92

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,250,993,800.00	1,172,537,187.36
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,250,993,800.00	1,172,537,187.36
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,249,293,800.00	1,170,837,187.36
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	932,916,000.00	874,655,960.32
210101	Үндсэн цалин	505,281,600.00	464,440,076.83
210102	Нэмэгдэл	270,926,400.00	268,227,321.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,608,000.00	69,658,292.00
210104	Урамшуулал	84,100,000.00	72,330,270.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	117,327,000.00	109,999,261.55
210201	Тэтгэврийн даатгал	85,046,400.00	75,575,832.29
210202	Тэтгэмжийн даатгал	8,070,200.00	8,810,129.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,456,100.00	6,940,575.73
210204	Ажилгүйдлийн даатгал	1,614,000.00	1,697,520.07
210205	Эрүүл мэндийн даатгал	16,140,300.00	16,975,204.46
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	119,604,600.00	118,590,678.81
210301	Гэрэл, цахилгаан	73,323,300.00	72,325,028.81
210302	Түлш, халаалт	44,470,000.00	44,470,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,811,300.00	1,795,650.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,176,100.00	16,117,729.39
210401	Бичиг хэрэг	2,574,000.00	2,569,100.00
210402	Тээвэр, шатахуун	11,533,300.00	11,525,152.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,716,000.00	859,476.89

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	208,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,144,000.00	1,164,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>26,000,000.00</b>	<b>19,547,200.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,000,000.00	19,076,200.00
210502	Хоол, хүнс	1,000,000.00	471,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,576,000.00</b>	<b>20,046,470.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,144,000.00	1,141,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,432,000.00	8,911,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,993,970.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,716,000.00</b>	<b>1,682,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,716,000.00	1,682,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,888,100.00</b>	<b>10,107,887.29</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,815,300.00	5,039,991.29
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	2,499,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240,800.00	240,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	99,601.00
210807	Газрын төлбөр	2,232,000.00	2,228,195.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>90,000.00</b>	<b>90,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	90,000.00	90,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,700,000.00</b>	<b>1,700,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,700,000.00</b>	<b>1,700,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	1,700,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,250,993,800.00</b>	<b>1,172,537,187.36</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,244,993,800.00</b>	<b>1,164,869,787.36</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,244,993,800.00	1,164,869,787.36
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>6,000,000.00</b>	<b>7,667,400.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	7,667,400.00

/ төгрөгөөр /

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Булган дахь гаалийн газар нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд эрхэм зорилго оршиж байна.

2022 онд "Мэдээллийн соёлыг нэвтрүүлж, мэдээллийн экосистем бүрдүүлэх замаар гаалийн байгууллагын дижитал хувьслыг өргөжүүлэн хөгжүүлэе жилийн ажлын зорилго тодорхойлж эдийн засгийн хөгжлийг дэмжих, гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гаалийн байгууллагын чадавхыг дээшлүүлэх зорилтуудын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө 46 ажил үйлчилгээ тусган байгууллагын стратеги зорилтыг хангахад чиглэсэн нийт 33, төсвийн шууд захирагчийн тусгайлан сонгосон тусгай 6, дотоод

ажил үйлчилгээнд тусгагдсан 7 ажил үйлчилгээний биелэлтүүдийг тус тус ханган ажиллажээ.

Монгол улсын Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/63 тоот тушаалын 19 дүгээр хавсралтаар Ховд аймгийн Булган дахь гаалийн газар 62 орон тоотой байхаар баталсан байна. Тайлант хугацаанд удирдах 1 төрийн тусгай 27, төрийн үйлчилгээний 17 нийт 45 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Гаалийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Байгууллагын даргын 2022 оны 06 сарын 21-ний өдрийн А/06 тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан өмч хамгаалах зөвлөл тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд Гаалийн ерөнхий газрын дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Өмч хамгаалах зөвлөл нь жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, актлах хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад **нийцсэн** тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Булган дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 80.0 сая төгрөгөөр буюу 3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	6.3	6.3
Бараа материал	91.8	104.3	12.5
Үндсэн хөрөнгө	2,603.7	2,664.8	61.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,695.5</b>	<b>2,775.4</b>	<b>79.9</b>
Өр төлбөр	-	0.3	0.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,695.5	2,775.2	79.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,695.5</b>	<b>2,775.5</b>	<b>80.0</b>

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ *Төрийн сангийн орон андуурч шивсэн алдаатай гүйлгээний улмаас нийгмийн даатгалын хэлтсээс авах авлага 6.3 сая төгрөгөөр нэмэгдсэн*
- ✓ *Бараа материал 12.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, үндсэн хөрөнгө 61.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь Гаалийн ерөнхий газраас үнэ төлбөргүй бараа хүлээн авсан, МХГ-ын экспорт импорт хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн балансад бүртгэлтэй үндсэн хөрөнгө балансаас балансад шилжиж ирсэнтэй холбоотой байна.*
- ✓ *Өр төлбөр 0.38 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ТӨБЗГ-т гэрээний дагуу түрээсийн төлбөрийн 40 хувийг шилжүүлээгүйгээс үүссэн байна.*
- ✓

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1244.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 6.0 сая төгрөг нийт 1250.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1244.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 7.5 сая төгрөг нийт 1252.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1172.5 сая төгрөг буюу 90 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 80.0 сая төгрөгөөр хэмнэж төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70205/80101-Зардал	1,245.1	1,165.9	79.2	94%
2	70205/80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх	2.4	1.6	0.8	68%
3	70205/80219-Харуул хамгаалалт	3.4	3.4	-	100%
4	70205/80802- Тэтгэвэр тэтгэмж	1.7	1.7	-	100%
<b>ДҮН</b>		<b>1,252.6</b>	<b>1,172.6</b>	<b>80.0</b>	<b>90%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

**4. АУДИТЫН ТАЙЛАН**

**4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган дахь Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын гүйцэтгэл, хөрөнгө, бараа материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг аудитор С.Оюунжаргал 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 02 дугаар сарын 08-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 14 албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1436.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 21.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17.2 сая төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардал гараагүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.**

Аудитаар байгууллагын санхүүгийн тайланд нөлөөлөл үзүүлэхүйц алдаа <sup>1</sup> илэрсэнгүй.

Аудитаар цаашид дотоод хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай нийт 12.5 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 12.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### **5.1 Зөвлөмж**

##### **5.1.1 Бараа материал данстай холбоотой**

**Илрүүлэлт 1:** Байгууллагын малыг зах зээлийн үнээр үнэлж данс бүртгэлд тусгаагүй, хямд үнэтэй, дансанд бүртгэгдсэн, ашиг шим, нас дэвшлийн тооцоо хийгээгүй зөрчил илэрлээ Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д төсвийн орлого зарлага хөрөнгө өр төлбөрийг нягтлан бодох бүртгэлийн холбогдох дансанд бүртгэх тайлагнах, 20 дугаар зүйлийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж :** Нягтлан бодох бүртгэлийн холбогдох заалтыг мөрдөн ажиллаж малын нас дэвшлийн үнэлгээг тогтоон зах зээлийн үнээр тусгах

**Илрүүлэлт 2:** Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн, нүүрсний зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулах ажлыг зохион байгуулах , удирдах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** 2 дугаар улиралд багтаан хөрөнгө бараа материалын тооллого хийж ангилан бүртгэх, нүүрс зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын малыг зах зээлийн үнээр үнэлж данс бүртгэлд тусгаагүй, хямд үнэтэй, дансанд бүртгэгдсэн, ашиг шим, нас дэвшлийн тооцоо хийгээгүй,	1	12,500.0					1	12,500.0
Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн,Түлээ нүүрсний зарцуулалтад тавих хяналт сул, ихээр нөөцөлсөн	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>12,500.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>12,500.00</b>

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  С.ОЮУНЖАРГАЛ